**Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн тухай**




Бага, дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаар тодорхойлогддог.

12.1.Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн.

12.2.Эзэмшүүлэх боловсролын түвшинг харгалзан ерөнхий боловсролын сургуулийг бага, дунд, ахлах сургууль гэж ангилна. Бага, дунд, ахлах сургууль нь цогцолбор хэлбэрээр хоршин ажиллаж болно.

12.3.Ерөнхий боловсролын сургууль нь ердийн, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, тусгай, олон улсын хөтөлбөрийн сургалттай гэсэн хэв шинжтэй байна.

12.4.Ерөнхий боловсролын сургуульд 6 настай хүүхдийг элсүүлнэ.

12.5.Ерөнхий боловсролын сургууль нь сургууль завсардсан, эсхүл сургуульд сурч байгаагүй хүүхэд, насанд хүрэгчдэд орой, эчнээ, бусад хэлбэрээр бага, суурь, бүрэн дунд боловсрол болон энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан мэдлэгийг эзэмшүүлж болно.

12.6.Ерөнхий боловсролын сургуульд захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, багш, нийгмийн ажилтан, бусад ажилтан ажиллана.

**Асгат сумын Хүүхдийн Цэцэрлэгийн тухай**



Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 4.1.1."хүүхдийн цэцэрлэг" гэж /цаашид "цэцэрлэг" гэх/ хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллагыг хэлэх бөгөөд мөн хуулийн 8 дугаар зүйлд зааснаар тодорхойлогддог.

8.1.Цэцэрлэг нь ердийн, тусгай, сувиллын, асрамжийн, халамжийн гэсэн хэв шинжтэй байна.

8.2.Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын стандартын дагуу асаргаа, сувилгаа, сургалтын үйлчилгээг дагнасан болон хосолсон хэлбэрээр явуулж болно.

8.3.Цэцэрлэг нь сургуульд элсэхийн өмнөх насны бүх хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.

8.4.Цэцэрлэг нь хамран сургах тойргийнхоо цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулж, тэдний эцэг, эх, асран хамгаалагчид мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.

**Асгат сумын Эрүүл мэндийн төвийн тухай**




Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.4."Эрүүл мэндийн байгууллага" гэж хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг хэлэх бөгөөд мөн хуулийн 20 дугаар зүйлд заасан дараах үүргийг хүлээндэг.

20.2.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, мэргэжлийн дээд шатны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, улсын байцаагчийн шаардлагыг биелүүлэх;

20.2.2.барилга байгууламж, оношлогоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмж болон холбогдох бусад техник хэрэгсэл нь эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан, эмнэлгийн ажилтны хөдөлмөрийн онцлогт тохирсон, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлсэн байх;

20.2.3.үйл ажиллагаандаа чанарын стандартын шаардлагыг хангах;

20.2.4.эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг нийтэд сурталчлах;

20.2.5.хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллах;

20.2.6.үйл ажиллагааныхаа тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж өгөх, бусад байгууллага, иргэнийг эрүүл мэндийн асуудлаар өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

20.2.7.эмнэлгийн мэргэжилтэнд мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, ажилтны нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

## Асгат сумын Соёлын төвийн тухай



Соёлын тухай хуулийн 3.1.2."Соёлын байгууллага" гэж энэ хуульд заасан журмын дагуу соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг хэлэх бөгөөд мөн хуулийн 25 дугаар зүйлд зааснаар дараах чиг үүрэг хүлээдэг.

25.2.Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордон нь тухайн орон нутгийн иргэний соёлын үйл ажиллагаа эрхлэх, бүтээл туурвих, соёлын ололт, үр шимийг хүртэх нөхцөлийг хангах, орон нутгийн байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг сурталчлах, номын сангийн үйлчилгээ хүргэх чиг үүрэгтэй соёлын боловсрол олгох анхан шатны байгууллага бөгөөд соёл, мэдээллийн төв байна.